

ТАНИЛЦУУЛГА

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өмгөөллийн тухай хуулиар иргэдийн хууль зүйн туслалцаа авах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхийг хангах, өмгөөлөгч, өмгөөлөгчдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдлыг тогтоож, өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан.

Түүнчлэн хамт батлагдсан Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд Өмгөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох, Монголын Хуульчдын холбоо болон Өмгөөлөгчдийн Холбооны үйл ажиллагааг уялдуулах, чиг үүргийг оновчтой хуваарилах, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулахаар тусгагдсан болно.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэхээр тусгагдсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нийцүүлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсныг танилцуулж байна.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 41 зүйлтэй.

Хуулийн төслийн зорилт нь хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах, хуульчид тавих нийтлэг шаардлагыг тодорхойлох, хуульч бэлтгэх сургалтын магадлан итгэмжлэл, Хуульчдын холбооны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох бөгөөд хуулийн төслийг дараах асуудлыг тусган боловсрууллаа.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим зэргийг тусгалаа.

Хоёрдугаар бүлэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалт, түүнийг зохион байгуулах, хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох ажил, хуульчийн шалгалтад орох тухай өргөдөл гаргах зэрэг хуульчийн шалгалттай холбогдсон харилцааг тусгалаа. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн ерөнхий зарчмыг хэвээр хадгалж, шалгалтад орох өргөдөл гаргах журам, мэргэжлийн дадлагад тооцох ажил, албан тушаалын талаарх зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, эрх зүйч мэргэжилтэй этгээдийг хуульчаар ажиллах боломжийг харьцангуй өргөжүүлсэн хүрээнд, шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулахаар тусгалаа. Мөн

шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, арбитрч, мөрдөгч, эвлэрүүлэн зуучлагч, эрх зүйн хөтөч зэргээр ажилласныг мэргэжлийн дадлага хийсэнд тооцохоор нэмж тусгасан болно.

Гуравдугаар бүлэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүнийг олгох журам, хуульчийн зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлэх, хуульчийн зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл, мөн хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгохтой холбоотой харилцааг тусгалаа.

Мөн хуульчдын бүртгэл, гадаад улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан иргэн Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулахаар тусгалаа.

Мөн энэ бүлэгт эрх зүйч мэргэжилтэй Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажилласан болон ажиллаж байгаа хүн өөрөө хүсэлт гаргаж, Хуульчдын холбоонд бүртгүүлснээр хуульчийн зөвшөөрлийг олгосонд тооцох зохицуулалтыг бий болголоо. Өөрөөр хэлбэл хууль зүйн өндөр мэргэжилтэй байх, энэ чиглэлээр тодорхой хугацаанд ажилласан байх болон бусад шаардлага шалгуурыг тус тусын хуулиар тусгайлан тавьсан тул уг албан тушаалд ажилласан болон ажиллаж байгаа тодорхой тооны этгээдэд хуульчийн зөвшөөрлийг олгох боломжтой гэж үзсэн болно.

Дөрөвдүгээр бүлэгт хуульчдыг давтан сургах, сургалтын чанарыг сайжруулах, хуульчдад хууль тогтоомжийг нэг мөр ойлгуулахад чиглэх зорилгоор шүүх, прокурор, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатчдын танхим, Хуульчдын холбоо сургалт, сургалтын хөтөлбөрийг харилцан уялдаатай, хамтран зохион байгуулахаар тусгасан.

Хуульчдын холбоо нь Үндсэн хуулийн эрх зүй, хуульчийн ёс зүйтэй холбоотой сургалтыг бие даан зохион байгуулахаар тусгалаа. Ингэхдээ хуульч нь хуульчийн үргэлжилсэн сургалтын нийт багц цагийн тодорхой хувийг Хуульчдын холбооноос зохион байгуулсан сургалтад суусан байхыг шаардах бөгөөд бусад багц цагийг энэ хуульд заасан аль ч байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах замаар хангах боломжийг олгохоор тусгалаа.

Тавдугаар бүлэгт “хуульч” нэрийг хэрэглэх, хуульчийн нийтлэг эрх, үүрэг, түүнд хориглох зүйл, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууц болон ёс зүйн дүрмийн талаарх зохицуулалтыг тусгалаа. Хуульч нь энэ хууль болон ёс зүйн дүрэмд захирагдан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах бөгөөд шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг тус тусын хуулиар нарийвчлан зохицуулах агуулгыг тусгасан болно. Өөрөөр хэлбэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд байгаа хуульчийн нэгдсэн хариуцлагын тухай зохицуулалт байх боломжгүй болж, хуульчийн хариуцлагын асуудлыг Монгол Улсын Шүүхийн тухай, Прокурорын тухай, Өмгөөллийн тухай, Нотариатын тухай, Төрийн албаны тухай хуулиар тус тус нарийвчлан зохицуулна.

Зургадугаар бүлэгт хуульч бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхтэй холбоотой харилцааг тусгалаа.

Ингэхдээ эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллага нь үндсэн ангийн сургалтын хөтөлбөрөөр эрх зүйч бэлтгэхэд бакалавр, эчнээ, оройн сургалтын хөтөлбөрөөр суралцагчид дипломын зэрэг олгохоор тусгалаа. Харин хуулийн төслийн энэхүү заалтын хувьд хууль хүчин төгөлдөр болсны дараах хичээлийн жилээс эхлэн дагаж мөрдөх зохицуулалтыг тусгасан. Ийнхүү дипломын зэрэг авч төгссөн этгээд нь үргэлжлүүлэн сурч, бакалаврын зэрэг авах эрх нь нээлттэй болно.

Түүнчлэн эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх зорилгоор суралцагч хууль зүйн мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх хичээлийг хууль зүйн сургуульд гурваас доошгүй жил судлах, төгсөхдөө судалсан нийт багц цагийн 30-аас доошгүй хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн хичээл байх шаардлагыг бий болгохоор тусгалаа.

Долдугаар бүлэгт хуульчийн мэргэжлийн шалгалт, хуульчийн үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий нийтийн эрх зүйн этгээд буюу Хуульчдын холбооны эрх зүйн байдал, бүтэц, зохион байгуулалтыг хууль тогтоомжийн хүрээнд оновчтой, үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлэн тусгалаа.

Хуульчдын холбоо нь хараат бус, бие даасан байх бөгөөд Их Хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Хяналтын хороо, ажлын алба, хуульчийн шалгалт, хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах болон эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжтэй байх, харин хууль, дүрэмд нийцүүлэн холбогдох нэгж, хороодыг байгуулан ажиллуулж болохоор тусгалаа.

Хуульчдын холбооны Их Хурлын гишүүдийн тоог шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч болон бусад хуульчдын төлөөлөл тус бүр 40 буюу нийт 200 төлөөлөгчтэй байх бөгөөд шүүгч, прокурор болон бусад хуульчдын төлөөллийг Хуульчдын холбоо, харин өмгөөлөгч, нотариатчийн төлөөллийг Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим хариуцан сонгон шалгаруулахаар тусгасан.

Хуульчдын холбооны Удирдах зөвлөл нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч болон бусад хуульчдын төлөөлөл бүхий 25 гишүүний, Хяналтын хороо нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүдийг Их Хурлаас сонгох бөгөөд Удирдах зөвлөлийн болон Хяналтын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх журмыг Хуульчдын холбооны дүрмээр зохицуулахаар тусгалаа.

Тус бүлэгт хуульч бүр холбооны гишүүн байхаар тусгасан бөгөөд харин Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нийцүүлэн хуульч нь шүүгчээр томилогдсон тохиолдолд Хуульчдын холбооны гишүүнчлэлээс өөрийн хүсэлтээр түдгэлзэж болох зохицуулалтыг тусгалаа.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Хуульчдын холбооны Их Хурал 2 жил тутамд хуралдах, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа мөн 2 жил, Хуульчдын холбооны зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 3 жилээр тус тус тогтоосон нь холбооны бодлого, журмын хэрэгжилт үр

нөлөөтэй, тогтвортой, уялдаа холбоотой хэрэгжих боломж муу, гишүүдийн сар тутам төлдөг хураамж дээр үндэслэдэг холбооны хөрөнгийг үргүй зарцуулах нөхцөлийг бий болгож байсныг өөрчилж, Хуульчдын холбооны Их Хурал, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг тус бүр 4 жил байхаар тусгасан болно.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хуульчийн зарим тодорхой үйл ажиллагааг хуульд заасан эрх бүхий этгээдэд мэдээлэх үүргийг хүлээлгэсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор хуулиудын уялдааг хангах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Хуульчдын холбоонд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхэд хяналт тавих нэгж ажиллуулж болохоор тусгаж, тус нэгжид ажиллах эрх бүхий этгээдэд тавих шаардлагыг Хуульчдын холбооны Удирдах зөвлөл холбогдох этгээдтэй хамтран батлах зохицуулалтыг тусгалаа.

Мөн энэ бүлэгт Хуульчдын холбооны санхүүжилтийн талаар тусгасан бөгөөд тус холбоо нь хуульчийн шалгалтын хураамж, үргэлжилсэн сургалтын төлбөр, хуульчийн бүртгэлийн хураамж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хураамж, хууль зүйн сургуулийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн төлбөр, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэхээр тусгалаа.

Харин хуульч нь сар бүр татвар төлөх, түүнийг 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй бол хуульчийн зөвшөөрлийг хүчингүй болгох зохицуулалтыг үйлчилж байсныг өөрчилж, зөвшөөрлийн хураамжийг жилд нэг удаа төлөх бөгөөд хураамжийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний дөрөвний нэгтэй тэнцүү хэмжээтэй байхаар тусгалаа.

Түүнчлэн Хуульчдын холбоо нь хуулийн хэрэгжилт, хуульч бэлтгэх үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллах, харин хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбооны бие даасан байдалд нөлөөлөхийг хориглох зэрэг асуудлыг тусгалаа.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.16-д заасны дагуу шүүгч нь багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт үл хамаарах ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон. Үүнтэй уялдуулан Нотариатын тухай хуулиар шүүхийн төлөөлөл нь нотариатын сахилгын хорооны болон мэргэшлийн хорооны гишүүнээр ажиллахаар тусгасныг өөрчлөх шаардлагаар Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан болно.

Түүнчлэн эрх зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжлэхээр тусгасан энэхүү хуулийн төслийн зохицуулалттай уялдуулан Дээд боловсролын тухай хуулийн сургалтын хөтөлбөрийг сайн дурын үндсэн дээр

магадлан итгэмжлэх зохицуулалтад өөрчлөлт оруулахаар мөн хуулийн төсөл боловсрууллаа.

Хуулийн төсөлд төрийн захиргааны нийт 22 байгууллагаас саналыг авч тусган саналын товчоог хийж хавсаргав. Мөн хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны цахим хуудаст 2020 оны 8 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн байршуулж, олон нийтийн саналыг авсан болно. Олон нийтээс хуульчийн шалгалтыг жилд нэгээс дээш удаа авч байх тухай саналууд ирүүлснийг тусгаж ажилласан болно.

---o0o---